

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалт

Огноо:	2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр
Төслийн дугаар нэр:	P170676: Дэлхийн банкны санхүүжилттэй Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл
Тендер шалгаруулалтын дугаар, нэр:	W-2A-11: “Дулааны 2А магистраль, ДХ-165 цэгээс ДХ-221 цэг хүртэлх 2Ф350 мм-ийн голчтой 0.95 км шугамыг 2Ф500 мм-ийн голчтой болгон өргөтгөх” барилга угсралтын ажил
Тендер ирүүлэх сүүлийн хугацаа:	2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 14:00 цагт

1. Энэхүү тендерийн урилга нь 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Дэлхийн банкны “НҮБ-ын Бизнесийн Хөгжил” гадаад цахим хуудас дээр нийтэлсэн Төслийн Худалдан авах ажиллагааны Ерөнхий мэдэгдлийн дагуу зарлагдаж байна.
2. Монгол Улсын Засгийн газар нь Олон улсын хөгжлийн ассоциацийн зээлийн санхүүжилтээр “Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх” төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд, энэхүү төслийн хүрээнд “Дулааны 2А магистраль, ДХ-165 цэгээс ДХ-221 цэг хүртэлх 2Ф350 мм-ийн голчтой 0.95 км шугамыг 2Ф500 мм-ийн голчтой болгон өргөтгөх” барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагааг санхүүжүүлнэ.
3. Эрчим хүчний яам эрх бүхий тендер оролцогчдоос “Дулааны 2А магистраль, ДХ-165 цэгээс ДХ-221 цэг хүртэлх 2Ф350 мм-ийн голчтой 0.95 км шугамыг 2Ф500 мм-ийн голчтой болгон өргөтгөх” барилга угсралтын ажил хийх зорилгоор битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.
4. Тендер шалгаруулалтыг Дэлхийн Банкны Зээлдэгч нарт зориулсан худалдан авах ажиллагааны журам, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МӨРДӨХ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА: Бараа, Ажил, Зөвлөх ба Зөвлөхийн бус үйлчилгээ (2016 оны 7 дугаар сар, 2020 оны 11 дүгээр сард шинэчилсэн)- ын дагуу дотоодын нээлттэй зах зээлд чиглэн өрсөлдөөнт тендер шалгаруулалтын аргаар явуулах бөгөөд худалдан авах ажиллагааны журамд тодорхойлсон эрх бүхий бүх тендер оролцогчдод нээлттэй байна. Мөн Дэлхийн Банкны ашиг сонирхлын зөрчлийн талаар баримтлах бодлогыг уг журмын 3.4. Сонирхлын зөрчил хэсэгт заасныг мөрдөнө.
5. Сонирхсон эрх бүхий тендер оролцогч нь ажлын өдрийн Улаанбаатарын цагаар 09:00 – 17:00 цагийн хооронд энэхүү урилгын төгсгөлд заасан хаягт хүрэлцэн ирж Төсөл хэрэгжүүлэх нэгжээс нэмэлт мэдээлэл авах, тендерийн баримт бичигтэй танилцах боломжтой.
6. Дотоодын давуу эрх тооцохгүй. Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил буюу 2019, 2020, 2021 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь **5,874,907,917.0 (Таван тэрбум найман зуун далан дөрвөн сая есөн зуун долоон мянга есөн зуун арван долоо)** төгрөгөөс багагүй байна.

- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: **4,112,435,541.0** (*Дөрвөн тэрбум нэг зуун арван хоёр сая дөрвөн зуун гучин таван мянга таван зуун дөчин нэг*) төгрөгөөс багагүй байна.
- Санхүүгийн тайлан: Тендерт оролцогч нь сүүлийн 3 жил (2019, 2020, 2021 онууд)-ийн аудитлагдсан санхүүгийн тайланг ирүүлнэ.
- Тусгай зөвшөөрөл:

Эрчим хүчний яамны ТЗ 5.2 “0.07-4.0 МПа /0.7-40.0 кгх/см²/ даралттай шугам, хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засварын ажил, түүний туршилт, тохируулгын ажил үйлчилгээ” болон түүнээс дээш ангиллын тусгай зөвшөөрөлтэй байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгээс дэлгэрэнгүй шаардлагыг үзнэ үү.

7. Сонирхсон тендерт оролцогч нь урилгын төгсгөлд заасан хаягт хандан бичгээр хүсэлтээ гаргаж, **250,000** (хоёр зуун тавин мянга) төгрөгийн хураамжийг эргэн үл төлөгдөх нөхцөлтэйгөөр төлсөнөөр тендерийн баримт бичгийг худалдан авч болно.

Төлбөрийн данс:

Дансны нэр: Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл

Дансны дугаар: 100900011954

Банкны нэр: Төрийн сан банк.

Баримт бичгийг гадаад улсад илгээх тохиолдолд нэмэлт 150,000 (нэг зуун тавин мянга) төгрөгөөр буухиа шуудангаар хүргүүлэх болно. Эрчим хүчний яам нь баримт бичиг алга болох эсхүл хугацаа хоцорч хүргэгдсэнтэй холбоотой ямар нэг хариуцлага хүлээхгүй.

8. Тендерийг **2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 14:00** цагт эсхүл түүнээс өмнө доорх хаягаар ирүүлнэ. Тендерийг цахимаар хүлээн авахгүй. Хугацаа хоцорсон тендерийг хүлээн авахаас татгалзана.

Тендер хүлээн авах хаяг: Монгол Улс, 17060, Улаанбаатар хот, ХУД, III хороо, Чингисийн өргөн чөлөө Засгийн Газрын XIV байр, Эрчим хүчний яам, 3 дугаар давхрын хурлын танхим

9. Тендерийн хамт **234,996,316.0** (*Хоёр зуун гучин дөрвөн сая есөн зуун ерэн зургаан мянга гурван зуун арван зургаа*) төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

10. Тендерийг **2023 оны 02 дугаар сарын 28-ны 14:00 цагт** доор заасан хаягаар хүрэлцэн ирж, нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдын төлөөллийг байлцуулан нээнэ.

Тендер хүлээн нээх хаяг: Монгол Улс, 17060, Улаанбаатар хот, ХУД, III хороо, Чингисийн өргөн чөлөө Засгийн Газрын XIV байр, Эрчим хүчний яам, 3 дугаар давхрын хурлын танхим

11. Энэхүү урилгын 7-р хэсэгт заасан тендерийн баримт бичиг худалдан авах хаяг:

Монгол Улс, 17060, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо,

Чингисийн өргөн чөлөө, Засгийн Газрын XIV байр,

Эрчим хүчний яам, 3-р давхар, 301 тоот, шинжээч Д.Төртүлга

Утас:+ (976)-51263074

И-мэйл: tortulga@energy.gov.mn